



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2018 оны 01 сарын 19 өдөр

Дугаар А/34

Мандлговь

Нөөцийн өвс, тэжээлийн үнэ тогтоох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3 а, 29.2, Гамшгаас хамгаалах хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1 дэх заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Малчин өрхүүдийн санал хүсэлт, цаг агаарын хүйтрэлт болон бэлчээрийн цасан бүрхэвч нэмэгдэж, малын идэш тэжээл хомсдож байгаатай холбогдуулан аймгийн өвс, тэжээлийн аюулгүйн нөөцөд хадгалагдаж байгаа болон сумдын өвс, тэжээлийн фондод хадгалагдаж байгаа өвс 1 боодлыг 8000 /Найман мянга/ төгрөг, тэжээл 1 шуудайг 11000 /Арван нэгэн мянга/ төгрөгөөр тооцож тус тус худалдан борлуулсугай.

Хоёр. Худалдаж борлуулсан өвс, тэжээлийн орлогыг аймгийн "Мал хамгаалах сан"- гийн 100080051404 тоот дансанд төвлөрүүлэхийг аймгийн Ерөнхий санхүүч /С.Энжаргал/-д үүрэг болгосугай.

Гурав. Өвс, тэжээлийг тогтоосон үнийн дагуу малчид, мал бүхий иргэдэд худалдан борлуулах арга хэмжээг авч ажиллахыг сумдын Засаг дарга нарт, захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг ХОХБТХэлтэс /Н.Эрдэнэ-Очир/-т тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



О.БАТ-ЭРДЭНЭ

0200120